



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр эрүүл мэндийн салбарт 2015 онд хэрэгжүүлэх их засварын ажлын жагсаалтын Аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудын их засвар 4-р мөрийг дор дурдсанаар өөрчилсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ барилгын их засварын ажлын жагсаалт дахь Эрүүл мэнд, спортын сайдын багцын ХҮИ.1.2.4-т Аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Говь-Алтай, Есөн булаг сум Нэгдсэн эмнэлэг /-ын ажлын төсвийг Улсын Гуравдугаар төв эмнэлгийн дээврийн засварын ажил болгон өөрчилсүгэй.

3. Энэхүү жагсаалтын хэрэгжилтэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 34.1.5-д зааснаар гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тул гэрээ шууд байгуулан ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /Т.Баярсайхан /-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081080